Иххэт	60655	67107	74.3	74.0	60655	67107	0.0	0.0
Мандах	46116	37365	60.8	47.1	45983	36072	133	1293
Өргөн	50625	50803	68.3	60.4	50484	46297	141	4605
Сайхандулаан	58015	45609	74.0	57.2	58033	44400	0.0	1209
Улаанбадрах	47257	46119	73.8	65.5	47261	46119	164	0.0
Хатанбулаг	61792	74703	59.4	64.9	61792	74703	0.0	0.0
Хөвсгөл	45738	43321	73.6	62.0	45738	42098	0.0	1223
Эрдэнэ	44365	43913	70.4	63.5	45471	44237	5	0.0
Сайншанд	39359	34035	66.5	55.0	41110	33427	184	1155
Замын-Үүд	8914	11059	56.7	71.8	8796	11040	118	26



## 8.3 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн 08 сард

Малын төрөл	Хорогдсон мал		Оны эхний малд эзлэх хувь		Өвчнөөр хорогдсон мал		Өвчнөөр хорогдсон малын эзлэх хувь	
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
	толгойн тоо		хувь		толгойн тоо		хувь	
Бүгд	894	28368	0.04	1.11	55	41	6.2	0.1
Адуу	48	1033	0.03	0.63	0	0	0.0	0.0
Үхэр	54	1440	0.06	1.39	4	9	7.4	0.6
Тэмээ	13	60	0.03	0.13	2	12	0.0	20.0
Хонь	271	10532	0.03	0.98	13	4	4.8	0.0
Ямаа	508	15303	0.05	1.31	36	16	7.1	0.1

## 8.4 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумаар, жил бүрийн 08 сард

Сумын нэр	Хорогдсон мал		Оны эхний малд эзлэх хувь		Өвчнөөр хорогдсон мал		Өвчнөөр хорогдсон малын эзлэх хувь	
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
	толгойн тоо		хувь		толгойн тоо		хувь	
Бүд	894	28368	0.04	1.11	55	41	6.2	0.1
Айраг	0	4785	0.0	2.37	0	0	0.0	0.0
Алтанширээ	0	200	0.0	0.13	0	0	0.0	0.0
Даланжаргалан	2	2066	0.0	0.98	0	0	0.0	0.0
Дэлгэрэх	190	82	0.08	0.03	0	9	0.0	11.0
Иххэт	0	150	0.0	0.08	0	0	0.0	0.0
Мандах	96	1474	0.05	0.77	6	5	6.3	0.3
Өргөн	87	9074	0.1	4.85	0	0	0.0	0.0
Сайхандулаан	3	901	0.0	0.45	0	2	0.0	0.2
Улаанбадрах	5	94	0.0	0.06	0	0	0.0	0.0
Хатанбулаг	69	165	0.0	0.06	18	0	0.0	0.0
Хөвсгөл	133	825	0.08	0.47	0	0	0.0	0.0
Эрдэнэ	66	5547	0.04	3.36	1	3	1.5	0.1
Сайншанд	113	2410	0.09	1.72	0	22	0.0	0.9
Замын-Үүд	130	595	0.24	1.74	30	0	23.1	0.0





## 8.5 ХАА-н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН СУДАЛГАА, жил бүрийн 08 сарын эцэст

	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2020 VIII	2021 VIII
	төгрөг				
Ингэний сүү	2000	-	-	2500	-
Ямааны ноолуур	55000	-	70000	55000	80000
Тэмээний шир	5000	-	-	-	10000
Адууны шир	10000	-	5000	5000	8000
Үхрийн шир	25000	-	300	2000	5000
Хонины арьс	500	3000	-	-	5000
Ямааны арьс	500	-	-	-	-

## 8.6 МАЛЫН ҮНИЙН СУДАЛГАА, сумаар, 2021 оны 08 сарын эцэст

	Ат /5 нас/	Сөөглон үрээ /4 нас/	Хязаалан гуна /3 нас/	Эр хонь	Эр ямаа
	мянган төгрөг				
Айраг	-	-	-	200.0	120.0
Алтанширээ	1400.0	1000.0	1500.0	200.0	120.0
Даланжаргалан	-	-	1200.0	250.0	200.0
Дэлгэрэх	-	-	-	200.0	150.0
Иххэт	-	-	-	200.0	130.0
Мандах	1400.0	900.0	1150.0	235.0	120.0
Өргөн	-	800.0	-	-	-
Сайхандулаан	-	800.0	-	180.0	120.0
Улаанбадрах	1300.0	1000.0	1400.0	230.0	170.0
Хатанбулаг	-	-	1500.0	280.0	200.0
Хөвсгөл	1550.0	1050.0	1300.0	280.0	210.0
Эрдэнэ	1000.0	800.0	-	220.0	190.0
Сайншанд	1500.0	1300.0	1250.0	250.0	200.0
Замын-үүд	1000.0	800.0	1000.0	250.0	150.0



ЕС.АЖ ҮЙЛДВЭР

9.1 НИЙТ БА БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр

	Нийт бүтээгдэхүүн			Борлуулалтын орлого		
	2020 I-VIII	2021 I-VIII	2021 I-VIII 2020 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2021 I-VIII 2020 I-VIII
	сая.төг		хувь	сая.төг		хувь
Дүн	113897.2	175254.0	153.9	176001.5	414445.5	2.4 <sup>2</sup>
А.өмчийн төрлөөр төрийн	4916.1	6702.8	136.3	6092.8	7455.2	122.4
хувийн	108981.1	168551.2	154.7	169908.7	406990.3	2.3 <sup>2</sup>
Б.ААН-ийн хэлбэрээр						
Хоршоо	8.3	18.2	219.3	11.2	23.4	2.1 <sup>2</sup>
Компани	108445.1	167708.9	154.6	169233.7	405887.4	2.3 <sup>2</sup>
УУГ	4916.1	6702.8	136.3	6092.8	7455.2	122.4
Өрхийн аж ахуй	527.7	824.1	156.2	663.8	1079.5	162.6

Тайлбар- <sup>2</sup>-дахин их

9.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН ЖИГД АЖИЛЛАГАА, сараар, оны үнээр

		Ажиллагчид	НБ	ББ	Сар бүрийн дүнд	
		тоо	сая.төг		хувь	
2020	I сар	1777	4474.4	18553.0	3.9	10.5
	II сар	1811	1951.2	4682.1	1.7	2.7
	III сар	1442	7399.5	12020.9	6.5	6.8
	IV сар	1535	14744.0	31699.1	12.9	18.0
	V сар	1826	23747.7	27388.1	20.9	15.6
	VI сар	1988	12172.9	29432.2	10.7	16.7
	VII сар	1997	25817.1	22037.2	22.7	12.5
	VIII сар	1994	23590.4	30188.9	20.7	17.2
	Дүн		113897.2	176001.5	100.0	100.0
2021	I сар	2239	8770.7	14620.4	5.0	3.5
	II сар	2232	15823.7	28595.4	9.0	6.9
	III сар	2210	19071.9	46399.3	10.9	11.2
	IV сар	2217	33379.4	99320.3	19.0	24.0
	V сар	2128	23648.3	43347.8	13.5	10.5
	VI сар	2125	26934.6	67300.7	15.4	16.2
	VII сар	2157	21514.4	35523.8	12.3	8.6
	VIII сар	2227	26111.0	79337.8	14.9	19.1
	Дүн		175254.0	414445.5	100.0	100.0



## 9.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар, оны үнээр, жил бүрийн эхний 08 сард

	2019 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2021 I-VIII 2020 I-VIII
	сая.төг			хувь
<b>Дүн</b>	<b>130982.6</b>	<b>113897.2</b>	<b>175254.0</b>	<b>153.9</b>
<b>Уул, уурхай олборлох үйлдвэр</b>	<b>62721.8</b>	<b>44010.6</b>	<b>97158.1</b>	<b>2.4<sup>2</sup></b>
Нүүрс олборлолт	62721.8	34835.1	89124.4	2.8 <sup>2</sup>
Бусад ашигт малтмал олборлолт		9175.5	8033.7	87.6
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>63795</b>	<b>63691.8</b>	<b>71393.1</b>	<b>112.1</b>
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	732.3	826.0	1290.6	156.2
мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	72.9	69.4	159.4	2.6 <sup>2</sup>
сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	141.7	148.8	130.2	87.5
хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	517.7	607.8	1001	164.7
Хувцас үйлдвэрлэл	46	46.5	44.5	95.7
Гутал үйлвэрлэл	9.1	14.5	13.7	94.5
Мод, модон эдлэл үйлдвэрлэл	30.7	44.8	37.9	84.6
Машин тоног төхөөрөмжөөс бусад жижиг үйлдвэрлэл	3.4	17.9	1.7	9.5
Боловсруулах үйлдвэрийн бусад	62973.5	62742.1	70004.7	111.6
<b>Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл</b>	<b>3156.8</b>	<b>3646.5</b>	<b>3657.3</b>	<b>100.3</b>
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	3156.8	3646.5	3657.3	100.3
<b>Усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа</b>	<b>1309</b>	<b>2548.3</b>	<b>3045.5</b>	<b>119.5</b>
Ус ариутгал, усан хангамж, хог хаягдал зайлуулах	1309	2548.3	3045.5	119.5

Тайлбар- <sup>2</sup>-дахин их



9.4 БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, СУМААР, ОНЫ ЭЦЭСТ

	Мэдээлэлд хамрагдсан нэгж		Нийт үйлдвэрлэлт		
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2021 I-VIII 2020 I-VIII
	Тоо		сая.төг		хувь
Дүн	70	79	113897.2	175254.0	153.9
Айраг	3	3	18.0	15.2	84.4
Алтанширээ	4	3	6.6	4.8	72.7
Даланжаргалан	4	4	65556.7	73377.2	111.9
Дэлгэрэх	0	0	0.4		0.0
Иххэт	3	3	8199.2	7553.6	92.1
Мандах	2	5	15.1	11.5	76.0
Өргөн	6	7	9139.6	10818.4	118.4
Сайхандулаан	0	0			
Улаанбадрах	4	3	1.5	0.4	26.3
Хатанбулаг	1	2	0.5	1.3	260.0
Хөвсгөл	4	2	20375.67	72965.9	4.2 <sup>2</sup>
Эрдэнэ	1	3	3.6	14.7	4.8 <sup>2</sup>
Сайншанд	24	29	7603.7	7503.2	98.7
Замын-Үүд	14	15	2976.6	2987.8	100.4

9.4 хүснэгтийн үргэлжлэл

Сумын нэр	Дулаан		Ус түгээлт		Сувагжуулалт		Савласан цэвэр ус	
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
	мян.ккал		мян.м3		мян.м3		мян.л	
Дүн	92.4	110.1	669.4	1050.8	498.5	825.5	1096.8	2205.3
Айраг								
Алтанширээ								
Даланжаргалан								
Дэлгэрэх								
Иххэт								
Мандах								
Өргөн							6.0	8.9
Сайхандулаан								
Улаанбадрах								
Хатанбулаг								
Хөвсгөл								
Эрдэнэ								
Сайншанд	32.4	47.3	469.8	732.0	360.1	657.9	545.4	642.3
Замын-Үүд	60.0	62.8	199.6	318.8	138.4	167.6	545.4	1554.1



## 9.4 хүснэгтийн үргэлжлэл

Сумын нэр	Талх		Нарийн боов		Бялуу		Хиам	
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
	тн		тн		тн		тн	
Дүн	204.9	187.4	65.2	43.9	2.4	4.0	11.4	25.1
Айраг	2.7	1.4	0.1	0.7	0.5			
Алтанширээ	2.8	2.8	0.1					
Даланжаргалан			7.5	3.5				
Дэлгэрэх								
Иххэт	20.7	9.4						
Мандах								
Өргөн	0.64	0.5	0.6	0.1	0.07			
Сайхандулаан								
Улаанбадрах	0.7	0.2						
Хатанбулаг								
Хөвсгөл	2.1	1.1						
Эрдэнэ	0.9	4.6	0.4	0.04		0.2		
Сайншанд	90.1	60.8	25.0	21.43	1.0	1.3	11.4	25.1
Замын-Үүд	84.3	106.6	31.4	18.1	0.8	2.5		

## 9.4 хүснэгтийн үргэлжлэл

Сумын нэр	Сүүн бүтээгдэхүүн		Хэрчсэн гурил		Банш,бууз		Гутал	
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
	мян.л		тн		тн		ширхэг	
Дүн	37.1	36.7	43.8	46.7	2.3	6.2	173	203
Айраг			0.03				162	199
Алтанширээ			1.2	1				
Даланжаргалан								
Дэлгэрэх								
Иххэт			4.1	0.6				
Мандах								1
Өргөн			0.5	1				
Сайхандулаан								
Улаанбадрах			0.4					
Хатанбулаг			0.2	0.9				
Хөвсгөл			0.1					
Эрдэнэ			0.4	4.2				
Сайншанд	37.1	36.7	29.0	31.6	2.3	3.4		
Замын-Үүд			7.9	7.4		2.8	11	3



## 9.4 хүснэгтийн үргэлжлэл

Сумын нэр	Нүүрс		Шохой		Вакуум цонх		Цемент	
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
	мян.тн		тн		м2		мян.тн	
Дүн	436.5	1413.4	13450.0	25000.0	1394.3	1116.0	509.4	628.5
Айраг								
Алтанширээ								
Даланжаргалан	291.1	375.7					419.6	522.9
Дэлгэрэх								
Иххэт								
Мандах								
Өргөн			13450	25000			89.8	105.6
Сайхандулаан								
Улаанбадрах								
Хатанбулаг								
Хөвсгөл	145.4	1037.7						
Эрдэнэ								
Сайншанд					1394.3	1116.0		
Замын-Үүд								

## 9.4 хүснэгтийн үргэлжлэл

Сумын нэр	Модон эдлэл		Дээл		Жижиг оёдол		Хайрга	
	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII	2020 I-VIII	2021 I-VIII
	мян.төг		ш		мян.төг		мян.м3	
Дүн	43631.5	29735.0	173	67	12234.3	8225.5	15.3	10.1
Айраг					1455.3			
Алтанширээ			6		305.0			
Даланжаргалан			27		1530.0			
Дэлгэрэх	300.0							
Иххэт								
Мандах		4350	97	48	5080.0	2270.0		
Өргөн			10	17	430.0	740.0		
Сайхандулаан								
Улаанбадрах				2				
Хатанбулаг								
Хөвсгөл			33		3434.0	5215.5		
Эрдэнэ								
Сайншанд	43331.5	25385					4.6	1.5
Замын-Үүд							10.7	8.6



## АРАВ. НЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН

## 10.1 ЦАГ УУРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, сумаар, 2021 оны 08 сард

Станцын нэр	Агаарын температур			Хөрсний температур			Тунадасны хэмжээ		Салхины хурд		Бэлчээрийн ургамал	
	Дундаж	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж	Хамгийн их	Хамгийн бага	Нийлбэр	Тундастай өдөр	их хурд	10м/с-ээс дээш салхитай өдөр	Дундаж өндөр	Ургац
	хэм						миллиметр		метр/секунд		см	ц/га
Айраг	20.8	34	9	27	-	-	37.1	7	12	6	10	0.4
Алтанширээ	21.2	-	9	25	-	7	22.1	5	12	8.0	12	0.4
Дэлгэрэх	19.1	34	8	24	55	7	68.9	8	16	9	20	0.8
Иххэт	20	29	9	24	54	8	111.7	15	12	5	16	0.3
Мандах	19.1	31	8	24	56	6	14.2	8	18	10	18	1
Өргөн	21.5	34	-	28	-	-	35.4	9	14	8	17	0.1
Сайхандулаан	20.3	-	9	28	-	-	18.5	7	12	6	11	0.1
Улаанбадрах	21.5	-	11	28	-	-	17.4	7	14	9	11	1
Хатанбулаг	21.8	-	9	29	58	7	43.5	6	17	2	16	1.4
Хөвсгөл	21.3	35	10	26	56	9	15.4	6	21	14	11	0.4
Эрдэнэ	19.4	34	8	24	57	8	33.4	9	23	12	9	0.3
Сайншанд	22.2	34	10	25	54	8	12.7	8	18	14	17	0.7
Замын-Үүд	20.2	34	10	25	57	8	23.3	11	16	16	18	0.2

Эх сурвалж: Цаг уур орчны шинжилгээний газар



## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2021 оны 08 дугаар сарын байдлаар)

### Нэг. Нийгмийн үзүүлэлт




#### 1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2021 оны 08 сард 967 эх амаржиж, 978 хүүхэд шинээр мэндэлж, 222 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 36(3.9%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 39(4.2%)-өөр тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 1(0.4%)-ээр буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 756 болж 2020 оны мөн үеийнхээс 40(5.6%)-өөр өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 13.8, нас баралт 3.1 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.2 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2018-2021 оны 08 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 10 байгаа нь өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.



#### 1.2 Эрүүл мэнд

2021 оны эхний 08 сарын байдлаар 302.3 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар, 7.7 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар тус тус өсч, 11.2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар буурчээ.






2021 оны эхний 08 сард 1077 эх жирэмсний хяналтанд орсны 93.2 хувь буюу 1004 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 12.1 мянган удаа гарсны 2.0 мянга буюу 16.5 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар, алсын дуудлага 13.0 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 1620 хүн бэртэж, 35 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 374(18.8%)-өөр, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 3(7.9)-аар тус тус буурсан байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2021 оны 08 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 28.4 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 23.4 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 15.8 хувь, бусад төрлийн өвчин 16.7 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 8.1 хувь, хоол шингээх эрхний өвчин 7.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 1209 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 731-ээр буюу 2 дахин өсчээ. Нийт бүртгэгдсэн халдварт өвчний 79.2 хувь буюу 957 нь шинэ төрлийн коронавируст халдварын тохиолдол юм. 2021 оны 08 сарын байдлаар Айраг суманд 27, Даланжаргалан суманд 35, Иххэт суманд 15, Мандах суманд 2, Өргөн суманд 18, Сайхандулаан суманд 43, Улаанбадрах суманд 5, Хатанбулаг суманд 15, Хөвсгөл суманд 3, Эрдэнэ суманд 13, Сайншанд суманд 477, Замын-Үүд суманд 258, Зүүнбаян багт 35, Сулинхээр ЦА-д 8 тохиолдол тус тус бүртгэгдээд байна.




### 1.3 Хөдөлмөр эрхлэлт

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 08 сарын эцэст 676 болсны 600 (88.8%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 76 (11.2%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 313(86.2%) хүнээр, өмнөх сараас 99 (17.2%) хүнээр илүү байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 361(53.4%) нь бүрэн дунд, 146(21.6%) нь дээд, 66(9.8%) нь тусгай дунд, 38(5.6%) нь техник мэргэжлийн, 48(7.1%) нь бүрэн бус дунд, 8(1.2%) нь боловсролгүй, 6(0.9%) нь бага, 3(0.4%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2021 оны 08 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2021 оны 08 сард шинэ ажлын байранд 256 иргэн орсны 90 нь байнгын ажлын байр, 5 нь улирлын чанартай, 161 нь түр ажлын байранд орсон байна.

Хөдөлмөрийн хэлтсээр дамжуулан ажилд зуучлагдан орсон иргэд 2021 оны эхний 08 сард 389 иргэн болсны 200 нь эмэгтэй байна. Тухайн сард бүртгэлтэй байсан 21 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 86 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.




Зураг. Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, ажил мэргэжлийн ангилалаар 2021 оны 08 сарын эцэст



#### 1.4 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 08 сарын байдлаар 33714.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6464.9 (23.7%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны 08 сард өмнөх оны мөн үеэс 6464.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 5365.2 (29.2%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгал 1021.4 (22.6%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 112.0 (5.8%) сая төгрөг, ҮОМШӨ-ийн даатгал 25.0 (1.3%) сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2021 оны 08 сард





Нийгмийн даатгалын сангийн зарлага 41764.4 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2360.0 (6.0%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 31214.0 (74.7%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5544.9 (13.3%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2406.9 (5.8%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1685.2 (4.0%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 913.4 (2.2%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг



Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2021 оны эхний 08 сард нийгмийн халамжийн сангаас 10635 иргэнд 2832.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан иргэд 11914 (52.8%)-оор, олгосон тэтгэвэр тэтгэмж 2982.2 (51.3%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийгмийн халамжийн сангийн зарцуулалт буурсан нь 2020 оны 09-р сараас эхлэн цалинтай ээж хөтөлбөр, жирэмсэн эхийн тэтгэмж, алдарт эхийн одонгийн тусламж, насны хишиг, ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжүүд и-халамж цахим системд шилжиж ХХҮЕГ-аас шууд арилжааны банкуу шилжүүлэг хийгддэг болсонтой холбоотой юм.


Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2021 оны 08 сард 1304 хүн хамрагдсан нь өмнөх оноос 47 (3.5%)-оор, олгосон тэтгэвэрийн хэмжээ 971.9 сая төгрөг болж 1411.8 (59.2%) сая төгрөгөөр тус тус буурчээ.

Нийгмийн халамжийн тэтгэмж 1171 иргэнд 789.3 сая төгрөг, амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 1048 иргэнд 658.9 сая төгрөг болон нийгмийн халамжийн сангаас 30 иргэнд 36.0 сая төгрөгийг зарцуулсан байна.


Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 7082 иргэн хамрагдаж, 375.8 сая төгрөгийг олгожээ.



Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/




### 1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2021 оны 08 дугаар сарын байдлаар 283 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 113 хүн гэмтэж, 7 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 5(1.8%)-аар, гэмтсэн хүний тоо 46(68.7%)-аар өсч, нас барсан хүний тоо 8(53.3%)-аар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 50(2.0 дахин)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 12(33.3%)-аар, нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4(80.0%)-өөр тус тус өсч, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 23(15.1%)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 8(47.1%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 7(46.7%)-оор, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 7(63.6%)-оор тус тус буурч, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.




Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 45.6 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 34.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 4.2 хувийг хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 3.2 хувийг нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, 3.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 9.2 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 70 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25(55.6%)-аар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Хатанбулаг, Хөвсгөл, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдэж, Мандах суманд өмнө оны мөн үеийнхтэй адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар






Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 618.5 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1177.8 (65.6%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 337.5(54.6%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 116(41.0%) нь гэр орон сууцандаа, 70(24.7%) нь согтуугаар, 45(15.9%) нь гудамж олон нийтийн газарт, 15(5.3%) бүлэглэн, 19(6.7%) нь гэр бүлийн хүчирхийлэл, 34(12.0%) нь эмэгтэй хүн оролцсон, 88(31.1%) нь өдрийн цагаар /14-19 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 701 хүн саатуулагдаж, 145 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2021 оны 08 сард




## Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт



### 2.1 Мөнгө, банк


Монгол банкны 08-р сарын мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 34.7 мянга болж өмнөх оноос 2.0(5.4%) мянган хүнээр буурч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 78.9 мянга болж өмнөх оны мөн үеээс 3.1 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2020-2021 он, сая.төг





Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2020- 2021 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 195.1 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 2473.0 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 2740.4 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 55.4 (39.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 5.9 тэр бум төгрөг болж, өмнөх сараас 926.0(13.5%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 808.9(4.5 %) сая төгрөгөөр тус тус буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 16.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 2.8(20.6%)тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.3 (25.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг. Зээл, төрлөөр, тэрбум төгрөг, 2021.08 сард








Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2021.08 сард



## 2.2 Төсөв, санхүү

2021 оны 08 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 19 482.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 82.9 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 19.0 хувиар буурсан байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 83.4 хувийг татварын, 6.7 хувийг татварын бус орлого, 10.0 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2021 оны 08 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 5870.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх



оны мөн үеэс 0.8 хувь буюу 48.7 сая.төг-өөр дутуу, төлөвлөгөөнөөс 10.3 хувь буюу 549.4 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



### 2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс 2021 оны 08 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар тус тус өсчээ.

**Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.5 хувиар өсөхөд:** согтууруулах бус ундааны бүлэг 0.3 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 2.5 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 1.4 хувь, тээврийн бүлэг 4.0 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлэг 1.3 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 2.3 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


**Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2 хувиар өсөхөд:** хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 14.0 хувь, согтууруулах бус ундааны бүлэг 2.3 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 10.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 2.3 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 10.6 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 11.5 хувь, тээврийн бүлэг 9.5 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 2.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлэг 1.3 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 10.9 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 5.6 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2021 оны 08 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)






Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020-2021 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 -2021 оны 08 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



### Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



#### 3.1 Хөдөө аж ахуй


Аймгийн хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1083.4 мянган хээлтэгч малын 712.1 мянга (65.7%) нь 2021 оны эхний 08 сард төллөсөн байна. Эм хонины 73.7 хувь, эм ямааны 62.4 хувь, үнээний 50.1 хувь, гүүний 44.6 хувь, ингэний 42.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 97.4 хувь буюу 694.9 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 37.9 (5.2%) мянгаар бага байна. Дэлгэрэх суманд 77.9 мянга, Хатанбулаг 74.7, Иххэт суманд 67.1 мянга, мянга, Алтанширээ суманд 62.1 мянга, Даланжаргалан суманд 59.3, Айраг суманд 50.0 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 56.3 хувийг эзэлж байна.




Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 08 сард аймгийн хэмжээнд 28368 болж, өмнөх оны мөн үеэс 27474 (31 дахин) толгойгоор илүү байна. Нийт хорогдсон малын 53.9 хувийг ямаа, 37.1 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 08 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Хөвсгөл суманд хамгийн их буюу 1550.0 мянган төгрөг, Эрдэнэ, Замын-Үүд сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Сайншанд суманд их буюу 1300.0 мянган төгрөг, Өргөн, Сайхандулаан, Эрдэнэ, Замын-Үүд сумдад хамгийн бага буюу 800.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ, Хатанбулаг суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Замын-Үүд суманд хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Хатанбулаг, Хөвсгөл сумдад хамгийн их буюу 280.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 180.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Хөвсгөл суманд хамгийн их буюу 210.0 мянган төгрөг, Айраг, Алтанширээ, Мандах, Сайхандулаан сумдад хамгийн бага буюу 120.0 мянган төгрөг байна.

Зураг. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 08 сард, мянган төгрөгөөр





### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 08 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 175254. сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 414445.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 61356.8 сая төгрөгөөр буюу 53.9 хувиар, нийт борлуулалт 238444.0 сая төгрөгөөр буюу 2.4 дахин өссөн байна.

2021 оны 08 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 53.9 хувиар өсөхөд уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 53147.5 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 7701.3 сая төгрөгөөр, усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар 497.1 сая төгрөгөөр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн салбар 10.8 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.8 хувийг төрийн, 96.2 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 4.3 хувь, компани 95.7 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 17.7 мян.ккал-аар, ус түгээлт 381.4 мян.м3-аар, сувагжуулалт 327.0 мян.м3-аар, савласан цэвэр ус 1108.5 мян.литрээр, бялуу 1.6 тонноор, хиам 13.7 тонноор, хэрчсэн гурил 2.9 тонноор, банш, бууз 3.9 тонноор, гутал 30 ширхгээр, нүүрс 976.9 мян.тонноор, шохой 11550.0 тонноор, цемент 119.1 мян.тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Зураг. Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт, салбараар, эзлэх хувь, 2021 оны 08 сард





## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин

#### Цаг уур

**Температур:** 8 сарын дундаж агаарын температур нийт нутгаар 22.9 – 26.1 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт нутгаар 35 - 38 градус дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Сайншанд, Мандах, Хөвсгөл, Эрдэнэ, Алтанүирээ сумдын нутгаар ОЖДундаж орчим байлаа. Бусад сумдын нутгаар ОЖД-аас дулаан. Хөрсний гадарга дээр нийт нутгаар шөнөдөө 9.0 - 12.0 градус дулаан, өдөртөө 58 - 65 градус дулаан байв.

**Хур тунадас:** Энэ сард нийт нутгаар бороо 4 - 11 өдөр бороотой байлаа. Сайншанд суманд 60.7 мм, Замын-Үүд суманд 90.7 мм, Мандах суманд 80.7 мм, Хөвсгөл суманд 82.7 мм, Дэлгэрэх суманд 20.1 мм, Эрдэнэ суманд 73.3 мм, Айраг суманд 35.7 мм, Алтанширээ суманд 4.6 мм, Өргөн суманд 31.0 мм, Сайхандулаан суманд 57.9 мм, Улаанбадрах суманд 80.1 мм, Хатанбулаг суманд 136.1 мм бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг олон жилийн дундаж /ОЖД/-тай харьцуулахад: Өргөн, Дэлгэрэх, Алтанширээ сумдад ОЖД-аас бага, Айраг суманд ОЖДундаж орчим. Бусад сумлын нутгаар ОЖД-аас ахиу бороо орсон байна.

**Салхи:** Энэ сард салхины хамгийн их хурд Айраг, Алтанширээ суманд 9 - 12 м/с, бусад сумдын нутгаар 14 - 23 м/с хүрсэн. 10 м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Хатанбулаг, Сайхандулаан сумдад 1 өдөр, бусад сумдад 4 - 17 өдөр салхи ихтэй, зарим үед цаг агаар тогтворгүй байлаа.

**Бэлчээрийн ургамал:** Бэлчээрийн ургамлын дундаж өндөр 6- 18 см, бэлчээрийн ургамлын ургалтын байдал сумын нутгийн 4 зүгийн үнэлгээгээр Эрдэнэ, Сайншанддын зүүн, Айрагын баруун, зүүн, өмнө, Иххэтийн өмнө хэсгээр дунд зэрэг, бусад нутгаар сайн байна. Өргөн, Сайхандулаан, Замын-Үүд ихэнх хэсгээр дунд ургамал шарлаж хатаж байна.

**МАА-н үйлдвэрлэлд:** Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй. Нийт нутгаар отор нүүдэл хийж мал ногоолуулах ажил явагдлаа. Малын усан хангамж ихэнх нутгаар дунд зэрэг байлаа.

\_\_\_\_\_ о О о \_\_\_\_\_